



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/106

Өлгий


**Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрлийг
дуусгавар болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Буянт сумын нутаг дэвсгэр "Хоёр хөхийн хоорондох булаг" нэртэй талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан "Тэнгэр эрч Буянт" ХХК, Өлгий сумын нутаг дэвсгэр "Чулуут толгой" нэртэй талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан "Жорга" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан тул дээрх аж ахуйн нэгжүүдийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг дуусгавар болгосугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/106, 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/253 тоот захирамжууд болон XV-83000001 (БӨ-001Х), XV-83000006 (БӨ-006Х) дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсугай.

3. Холбогдох өөрчлөлтийг бүртгэлд бүртгэж, аймгийн Мэргэжлийн хяналтын газарт мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /З.Болаг/-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА *[Signature]* АТГЫЛЫМХАН